



Bank of Mongolia

# БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ БА ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

/2018.11.16/



# 1. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ:

## **Эрх зүйн тогтолцооны шинэчлэл:**

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, банкны үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчин зэрэг макро болон микро хүчин зүйлсээс шалтгаалж нийт активт эзлэх чанаргүй активын хувь харьцангуй өндөр байгаа нь санхүүгийн зуучлалд тасалдал үүсгэх, банк санхүүгийн байгууллагын зардлыг нэмэгдүүлэх замаар өндөр хүү тогтооход хүргэх, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэлтэй байна.

Банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах, ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 140/400/А-168/38 дугаар хамтарсан тушаалаар баталлаа.



## 1. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ:

### **Стратегийн баримт бичгийн агуулга:**

Энэхүү стратеги нь банкны системийн чанаргүй активын нөхцөл байдлыг тодорхойлж, хууль, эрх зүй, шүүхийн шинэчлэлийг хийх болон банкуудын чанаргүй зээлтэй ажиллах ажиллагааг үр дүнтэй болгон сайжруулах агуулгаар хэрэгжих юм.

**Эцсийн зорилго: Банкны системийн чанаргүй зээлийн хувийг 2021 он гэхэд 4-5, 2023 он гэхэд 2-3 хувь хүртэл бууруулах.**

ᠮᠤᠨᠭᠣᠯᠠᠨ  
ᠪᠠᠨᠭᠠᠨ



# 1. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ:

## **Стратегийн хүрээнд зээлийн эрсдэлийг бууруулах эрх зүйн тогтолцооны шинэчлэлийн чиглэл:**

- зээл, барьцааны гэрээний талуудын хооронд үүссэн маргааныг богино хугацаанд шийдвэрлэх;
- Барьцаа хөрөнгийн эргэлтийг сайжруулах;
- Өр төлбөрийг албадан барагдуулах ажиллагааг сайжруулах;
- Хуулийн этгээдийн дампуурлын эрх зүйн орчинг үр дүнтэй болгох;
- Банкны дахин хөрөнгөжүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;
- Чанаргүй активын зах зээл хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;
- Шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох.

Дээрх чиглэлээр холбогдох хуулиудад 2018-2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилт нь ОУВС-ийн хөтөлбөрийн биелэлтийг тооцох үндсэн шалгуур үзүүлэлт нэг юм.

11/15/2018



# 1. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ:

| № | Нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн нэр   | Нэмэлт өөрчлөлтийн агуулга   |
|---|---|--|
| 1 | Иргэний хууль   | Зээлдүүлэгчийн мөнгөн төлбөрийн шаардах эрхийг баталгаажуулах, шүүхэд хандсанаас үл хамааран зээлийн хүүг хуримтлуулан тооцдог байх зохицуулалтыг тусгах |
| 2 | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль   | Зээл, өр төлбөр барагдуулах талаар гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх ажиллагаа удааширч, саатдаг байдлыг арилгах  |
| 3 | Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль  | Барьцаалуулагчид мэдэгдэл хүргүүлэх ажиллагааг хялбарчлах, Барьцааны зүйлийг худалдах журмыг нарийвчлан зохицуулах.                                      |
| 4 | Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль | Эд хөрөнгийн бүртгэл, барьцааны бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах  |
| 5 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль   | Шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой хуулиудын давхцал, хоорондоо нийцгүй байдлыг бууруулах чиглэлд холбогдох хууль эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах         |
| 6 | Дампуурлын тухай хууль  | Хуулийг шинэчлэн найруулж, батлуулах   |

ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠳᠡᠭᠡᠨ  
ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠯ



# 1. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ:

## **Шинээр боловсруулж буй хууль, журмын төслийн тухай:**

- Монголбанкны зүгээс боловсруулсан **Активын удирдлагын компанийн тухай хуулийн төслийг** УИХ-аар батлуулахаар өргөн бариад байна.

Үр дүн: Активын удирдлагын компанийн эрх зүйн орчныг бүрдүүлснээр банк, санхүүгийн байгууллагуудад хуримтлагдаж буй чанаргүй зээл, авлагыг гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэх замаар бууруулах нөхцөл бүрдэх юм.

- Монголбанкны зүгээс **Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.**

Үр дүн: Банк, санхүүгийн байгууллагаас санхүүгийн хэрэглэгчийн чадавхи, бололцоонд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх замаар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, нөгөө талаар зээлийн эрсдэлийг бууруулах зорилготой.

- Чанаргүй активтай ажиллах банкуудын удирдлага, чадварыг сайжруулах хүрээнд **“Чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журам”-ыг** Хяналт шалгалтын газрын зүгээс боловсруулж байна.

11/15/2018



# 1. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ:

## **Нэмэлт өөрчлөлт оруулсан журам, заавар:**

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-201 дүгээр тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-д дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- ❖ Зээлийн бодит хүүгийн хувь хэмжээг зээлдэгчид өгөх;
- ❖ Зээлийн хүүг жилээр гарган, зээлдэгчид төөрөлдүүлэхээс урьдчилан сэргийлэх;
- ❖ Зээлийн хүүг урьдчилан авсан тохиолдолд Банкны тухай хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авах.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠪᠠᠨᠭᠠᠨ  
Bank



## 2. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

**Өнөөгийн байдал:** Монголбанк нь санхүүгийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын зээлийн эрсдэл болон хуримтлагдсан чанаргүй зээл, өр, авлагын хэмжээг бууруулах, зээлдэгчийн санхүүгийн сахилга батыг сайжруулах замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд өөрийн харъяанд зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа явуулж байна.

- ❖ 14 арилжааны банкууд, 1 Хөгжлийн банк, 444 банк бус санхүүгийн байгууллага, 105 хадгаламж зээлийн хоршоо болон ТОССК, МИК, Зээлийн батлан даалтын сан, лизингийн компани, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг яам агентлагуудын дэргэдэх сангууд, гар утасны оператор компани зэрэг төрийн болон хувийн хэвшлийн 564 гаруй байгууллага Монголбанкны Зээлийн мэдээллийн санд хандах эрхээ аваад байна.
- ❖ Зээлийн мэдээллийн санд 1.7 сая орчим зээлдэгч иргэд, 22.0 мянган аж ахуйн нэгжийн нийт 9.7 сая орчим зээлийн мэдээлэл хадгалагдаж байна.
- ❖ Зээлийн мэдээллийн санд хандах эрх авсан болон мэдээлэл нийлүүлэгч нийт 650 гаруй хэрэглэгчээс сард дунджаар 575,000 хандалт хийж, 1.6 сая зээлийн мэдээллийн лавлагааг авч байна.





## 2. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

**Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт:**

- Олон улсын валютын сангийн зүгээс Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай 2017 оны 7, 10 дугаар сард танилцаад тус үйл ажиллагаа нь олон улсын стандарт, шаардлагыг хангахгүй байна гэсэн дүгнэлтийг өгсөн.

Үүний дагуу 2018 оны 01 дүгээр сард ОУВС, Дэлхийн банк, ОУСК болон ХШГ-ын хамтарсан хурлыг хийж, ОУСК-ийн зүгээс Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар хөндлөнгийн дүгнэлтийг хийж, хамтран ажиллахаар тогтсон.

- Дээрх шийдвэрийн дагуу ОУСК-ийн зүгээс Монголбанкны зээлийн мэдээллийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээг хийж, холбогдох дүгнэлтийг 2018 оны 4 дүгээр сард Монголбанкинд ирүүлсэн.

ᠮᠣᠩᠭᠣᠯ  
ᠪᠠᠨᠭ



## 2. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

**Зээлийн мэдээллийн талаар ойрын хугацаанд авч буй арга хэмжээ:**

### **ОУСК-ийн оролцоо:**

Монголбанкны зээлийн мэдээллийн үйл ажиллагаатай танилцсан байдал, зээлийн мэдээллийн сангийн өнөөгийн болон цаашдын хэрэгцээ, шаардлагыг харгалзан ОУСК-иас дараах техникийн туслалцааг санал болгож байна.

Үүнд:

- Зээлийн мэдээллийн тайлагналын тогтолцоо, үйл ажиллагааг олон улсын сайн туршалагад нийцүүлэх хүрээнд **програм хангамж** худалдан авахад зөвлөгчөөр оролцох.
- **Зээлийн тайлагналын тогтолцоо, бүтэц, эрх зүйн орчныг (заавар, журам) сайжруулах** чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх.
- Зээлийн мэдээллийн талаарх олон нийтийн ойлголт, боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- *Үр дүн: Монголбанкны зээлийн мэдээллийн ашиглалтыг сайжруулах, системийн эрсдэлийн үнэлгээнд ашиглагдах тайлан мэдээг гаргаж авах, цаашлаад макро зохистой бодлогын судалгаа, шинжилгээ хийх, шийдвэр гаргах нөхцөл боломжийг бүрдүүлэх юм.*

ᠮᠣᠩᠭᠣᠯ  
ᠪᠠᠨᠭᠠᠨ



## 2. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

ОУСК-ийн зүгээс Монголбанкны зээлийн мэдээллийн үйл ажиллагаанд нийцсэн зээлийн мэдээллийн сангийн програм хангамжид тавигдах шаардлагыг ирүүлсэн тохиолдолд ХШГ- олон улсын түвшинд зээлийн мэдээллийн програм хангамж нийлүүлэх тендер зарлах ажиллагааг эхлүүлнэ. :



ХШГ



# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

МОНГОЛЫН  
ХАМГААГАХ,  
ХӨРСӨӨЛӨӨН  
АЖААЛ  
ГАРГАХ  
ЯАМ